





НАЛАЙХ ДҮҮРГИЙН  
СТАТИСТИКИЙН  
ХЭЛТЭС














ДҮҮРГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН  
ЗАСГИЙН БАЙДАЛ  
2024/08



[www.ubstat.mn](http://www.ubstat.mn)  
[www.1212.mn](http://www.1212.mn)  
[nalaikh@nso.mn](mailto:nalaikh@nso.mn)  
7023-3672



АГУУЛГА

	Хуудасны дугаар
 ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТ, 2020-2024 ОН	2
 ИРГЭНИЙ БҮРТГЭЛ	5-6
 НИЙГМИЙН ДААТГАЛ	7-8
 ЭРҮҮЛ МЭНД	8-9
 СОЁЛ УРЛАГ, БИЕИЙН ТАМИР	10
 АМЬДАРЧ БУЙ ОРЧИН	10-11
 ГЭМТ ХЭРЭГ	11-12
 ТӨСӨВ	13
 ТҮҮХИЙ ЭДИЙН ҮНЭ	13-14
 АЖ ҮЙЛДВЭР	14-15
 ХАРИЛЦАА ХОЛБОО	16
 АЮУЛГҮЙ БАЙДАЛ	16-17
 ӨРГӨДӨЛ ГОМДОЛ, ШИЙДВЭРЛЭЛТ	18





ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

Хүснэгт 1. Дүүргийн эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлт, жил бүрийн VIII сард

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2020	2021	2022	2023	2024
Суурин хүн ам, жилийн эцэст	тоо	38 690	38 929	39 579	40238	-
Шинээр төрсөн хүүхэд	тоо	616	636	472	545	440
Нас баралт	тоо	168	171	163	181	184
Халдварт өвчнөөр өвчилсөн хүн	тоо	283	4 516	4 550	290	208
Бүргэсэн гэмт хэрэг	тоо	251	171	252	355	246
Гал түймрийн дуудлага	тоо	34	27	42	44	58
Орон нутгийн төсвийн орлого	сая төгрөг	23 331.9	16 708.2	10 004.0	11 896.7	15 311.4
Орон нутгийн төсвийн зарлага	сая төгрөг	24 021.3	15 018.6	10 360.7	11 518.7	15 828.3

Эх үүсвэр: Санхүү, төрийн сангийн хэлтэс





## ИРГЭНИЙ БҮРТГЭЛ


2024 оны эхний 8 сард шинээр төрсөн 440 хүүхдийг иргэний бүртгэлд бүртгэн авч, нас барсан 184 хүнийг бүртгэлээс хасаж, 112 гэрлэлт, 42 хосын гэр бүл цуцлалтыг тус тус бүртгэсэн байна.

Шинээр мэндэлсэн хүүхдийн тоог өмнөх оны мөн үетэй харьцуулахад 105 хүүхдээр (19.3%) буурч, нас баралт өмнөх оны мөн үеэс 3 (1.6%) өссөн байна. Нийт мэндэлсэн хүүхдийн 53.4 хувь нь хүү, 46.6 хувь нь охин байна. Нас баралтад 65.2 хувь нь эрэгтэй, 34.8 хувь нь эмэгтэй хүн эзлэж байна.

### Хүснэгт 2. Төрөлт, нас баралтын бүртгэл, жил бүрийн I-VIII сард

Үзүүлэлт	2020	2021	2022	2023	2024
Төрсөн хүүхэд, бүгд	616	634	472	545	440
Үүнээс: Эрэгтэй	323	333	229	249	235
Эмэгтэй	293	301	243	238	205
Нас баралт, бүгд	168	171	163	181	184
Үүнээс: Эрэгтэй	108	97	102	107	120
Эмэгтэй	60	74	61	74	64

### Зураг 1. Хүн амын ердийн цэвэр өсөлт



### Хүснэгт 3. Бүртгүүлсэн гэр бүл, насны бүлгээр, жил бүрийн I-VIII сард

Үзүүлэлт	2022			2023			2024		
	Бүгд	эрэгтэй	эмэгтэй	Бүгд	эрэгтэй	эмэгтэй	Бүгд	эрэгтэй	эмэгтэй
Нийт	202	101	101	288	144	144	224	112	112
18-19	5	1	4	3	-	3	4	1	3
20-24	44	19	25	53	25	28	45	16	29
25-29	77	35	42	97	49	48	76	42	34
30-34	46	27	19	53	27	26	42	23	19
35-39	17	12	5	38	19	19	9	5	4
40-44	3	1	2	22	14	8	13	7	6
45-49	6	3	3	14	5	9	18	10	8
50 +	4	3	1	8	5	3	17	8	9



2024 оны эхний 8 сард гэрлэлтээ баталгаажуулсан 112 хос байгааг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 32 (22.2%) буурсан байна. Хосуудыг насны бүлгээр нь авч үзвэл 1.8% нь 18-19 насны, 20.1% нь 20-24 насны, 33.9% нь 25-29 насны, 18.7% нь 30-34 насны, 4.0% нь 35-39 насны, 5.8% нь 40-44 насны, 8.1% нь 45-49 насны 7.6% нь 50-аас дээш насныхан байна.

Хүснэгт 4. Гэр бүл цуцлалт, жил бүрийн I-VIII сард

Үзүүлэлт		2020	2021	2022	2023	2024
Гэр бүл цуцлалт, бүгд		21	28	50	44	42
Гэр бүл байсан хугацаагаар (жилээр)	1 хүртэл	1	-	1	3	5
	1-3	2	5	18	4	4
	4-6	-	3	8	5	7
	7-9	-	7	3	8	10
	10-14	13	7	6	9	10
	15-19	3	-	4	8	3
	20 ба түүнээс дээш	2	6	10	7	3

2024 оны эхний 8 сард нийт 42 хос гэр бүлээ цуцлуулсан байна. Гэр бүл байсан хугацаагаар нь ангилбал, 11.9% нь 1 хүртэл жил, 9.6% нь 1-3 жил, 16.7% нь 4-6 жил, 23.8% нь 7-9 жил, 23.8% нь 10-14 жил, 7.1% нь 15-19 жил, 7.1% нь 20-оос дээш жил ханилсан хосууд байжээ.

Дүүргийн хэмжээнд бүртгэгдсэн гэр бүл цуцлалтын үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4. 5 хувиар буурсан байна.

Дүүрэгт 2024 оны эхний 8 сард үрчлэгдсэн нийт 9 хүүхэд байна. Үүнээс 7 (77.8%) эрэгтэй, 2 (22.2%) эмэгтэй хүүхэд байна.

Хүснэгт 5. Үрчлэлтийн үзүүлэлт, жил бүрийн I-VIII сард

Үзүүлэлт		2020	2021	2022	2023	2024
Үрчлэгдсэн хүүхэд, бүгд Үүнээс: насны бүлгээр		12	7	11	17	9
3 хүртэл		6	4	4	11	4
3-6		2	1	-	-	1
7-9		2	1	3	3	1
10 ба түүнээс дээш		2	1	4	3	3

Эх үүсвэр: Налайх дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэс





## НИЙГМИЙН ДААТГАЛ

2024 оны эхний 8 сард нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 13229,4 сая төгрөгт хүрч, нийгмийн даатгалын санд төвлөрчээ. Нийгмийн даатгалын сангаас 2024 оны эхний 8 сард 50291 даатгуулагч иргэнд 39982.4 сая төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж олгосон байна.

Хүснэгт 6. Нийгмийн даатгалын сангийн зарцуулалт, жил бүрийн I-VIII сард

Үзүүлэлт	2023		2024	
	Даатгуулагч-дын тоо	Олгосон дүн (сая төгрөг)	Даатгуулагч-дын тоо	Олгосон дүн (сая төгрөг)
Нийт орлого	-	10 270.5	-	13 229.4
Тэтгэврийн даатгалын сан	-	8 633.0	-	11 101.6
Тэтгэмжийн даатгалын сан	-	893.3	-	1 155.7
ҮОМШӨ-ний даатгалын сан	-	580.7	-	759.7
Ажилгүйдлийн даатгалын сан	-	163.5	-	212.4
Нийт зардал	50 622	29 460.1	50 291	39 982.4
Тэтгэврийн даатгалын сан	44 201	25 732.7	45 451	34 551.6
Өндөр насны тэтгэвэр	31 338	18 200.9	32 895	24 688.4
Тахир дутуугийн тэтгэвэр	6 360	2 779.3	6 166	3 376.2
Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	2 462	1 104.5	2 321	1 323.5
Цэргийн тэтгэвэр	4 041	3 647.9	4 069	5 163.5
ҮОМШӨ-ний даатгалын сан	2284	2149.3	3 106	2 790.5
Тахир дутуугийн тэтгэвэр	1 801	2046.7	2 868	2 671.1
Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	95	81.5	128	96.4
Сувилалын зардал	339	7.8	98	13.1
ҮОМШӨ ХЧТА <sup>1</sup>	49	13.2	12	9.9
Тэтгэмжийн даатгалын сан	3343	904.1	784	1 528.7
Хөдөлмөрийн чадвар түр алдсаны	1 922	88.9	307	146.0
Жирэмсний амралт	1 040	601.2	331	1 089.2
Оршуулга	381	214.0	146	293.5
Ажилгүйдлийн даатгалын сан	794	674.0	950	1 111.5
Ажилгүйдлийн тэтгэмж	794	674.0	950	1 111.5


Эх үүсвэр: Нийгмийн даатгалын хэлтэс

Тэтгэврийн даатгалын сангаас 2024 оны эхний 8 сард өндөр насны тэтгэвэр авагч 32895 иргэдэд 24688.4 сая төгрөг олгосон байна. Нийт тэтгэврийн сангийн 71.4 хувийг өндөр насны, 9.8 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн, 3.8 хувийг тэжээгчээ алдсан, 14.9 хувийг цэргийн тэтгэвэрт зарцуулсан байна.

<sup>1</sup>Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчин, хөдөлмөрийн чадвараа түр алдсан



Зураг 2. Даатгалын сангийн зарлага



### ЭРҮҮЛ МЭНД

2024 оны эхний 8 сард төрсөн эхийн тоо өмнөх оны мөн үеэс 125 (22.2%), нас баралт 6 (3.5%) тус тус буурсан байна.

Хүснэгт 7. Төрөлт жил бүрийн I-VIII сард

Үзүүлэлт	2020	2021	2022	2023	2024
Амаржсан эхийн тоо, бүгд	599	627	541	563	438
Амьд төрсөн хүүхэд	605	636	544	571	442
Амьгүй төрсөн	2	2	3	1	6
Эхийн эндэгдэл	1	-	-	-	-
Нас баралт	175	202	166	173	167
Үүнээс: нэг хүртэл насандаа эндсэн хүүхэд	7	12	5	8	2
Эмнэлгийн нөхцөлд гарсан нас баралт	11	29	15	16	28
Гэрийн нөхцөлд гарсан нас баралт	139	139	113	130	107
Улаанбаатар хотод бүртгэгдсэн нас баралт <sup>2</sup>	25	34	38	27	32

2024 оны эхний 8 сард бүртгэгдсэн нийт нас баралтын 64.1 хувийг гэрийн орчин нөхцөлд гарсан нас баралт эзэлж байгаа бол 19.2 хувийг Улаанбаатар хотод хэвтэн эмчлүүлж байгаад гарсан, 16.7 хувийг дүүргийн эмнэлэгт гарсан нас баралт эзэлж байна.

Хүснэгт 8. Дүүргийн хэмжээнд гарсан халдварт өвчин, жил бүрийн I-VIII сард

Үзүүлэлт	2020	2021	2022	2023	2024
Нийт халдварт өвчин	283	4 516	4 550	290	208
Халдварт өвчин:	41	4 358	4 394	137	100
Хепатит В, С вирус	3	2	-	-	3
Менингет	1	-	-	-	-
Салхин цэцэг	13	6	9	30	63
Паротит	1	1	-	1	4

<sup>2</sup>Дүүргийн харьяат иргэдээс Улаанбаатар хотын эмнэлгүүдэд хэвтэн эмчлүүлж байгаад гарсан нас баралт




Бруцеллез	-	-	1	-	
Ёлом	1	1	1	-	
Дизентери	7	-	3	7	7
Гар, хөл,амны өвчин	2	2	3	19	14
Улаан эсэргэнэ	6	1	1	9	3
Хачигт риккетсиоз	2	-	-	-	-
Хоолны хордлого	-	-	-	-	2
Гэдэсний халдвар				4	-
Бүслүүр үлд	-	-	-	5	-
Сальмонеллөз	-	-	-	-	4
Энтеровирус тодорхойгүй	-	-	-	6	-
Ковид	5	4 345	4378	54	-
Сүрьеэ	33	40	23	27	16
Арьс өнгөний өвчин	209	118	133	126	92
Тэмбүү	58	48	52	60	49
Заг хүйтэн	52	37	47	29	20
Бэлгийн замын мөөгөнцөр	54	14	5	19	15
Арьсны мөөгөнцөр	-	-	-	-	-
Трихомониаз	45	19	29	18	8

Эрүүл мэндийн үзүүлэлтээр дүүргийн хэмжээнд нийт халдварт өвчнийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 82 хүн (28.3%), хурц халдварт өвчин 37 хүн (27.0%), арьс өнгөний өвчлөл 34 хүн (26.9%), сүрьеэгээр 11 хүн (40.7%) тус тус буурсан үзүүлэлттэй байна.

#### Хүснэгт 9. Эмнэлгийн үзлэгийн үзүүлэлт, жил бүрийн I-VIII сард

Үзүүлэлт	2020	2021	2022	2023	2024
Урьдчилан сэргийлэх тарилга	4 535	4 360	4 129	4 308	3744
Амбулаторын үзлэг	132 278	138 072	146 293	145 226	154 075
Ор хоног	32 568	33 105	36 526	37 770	37 956
Эмчийн тоо	76	84	84	93	94
Сувилагчийн тоо	108	100	100	108	111
Орны тоо	227	227	325	227	227

#### Зураг 3. Эмнэлгийн үзлэгийн үзүүлэлт



Амбулаторийн үзлэгийг өмнөх оны мөн үетэй харьцуулж үзэхэд 8849 (6.1%), ор хоног 186 (0.5%)-иар тус тус өсч, урьдчилан сэргийлэх тарилга 564 (13.1%) буурсан байна.

Эх үүсвэр: Эрүүл мэндийн төв





## СОЁЛ УРЛАГ

Дүүргийн соёл, урлагийн байгууллага 2024 оны эхний 8 сард нийтдээ 8 төрлийн 87 ажил, үйлчилгээг явуулж, 22039 хүнд үйлчилсэний 12397 (56.3.8%) том хүн, 9642(43.7%) нь хүүхэд байна. Үйлчилгээний нийт орлого 20311.0 мянган төгрөг байна.

Хүснэгт 10. Соёл, урлагийн үйл ажиллагааны үндсэн үзүүлэлт, 2024 оны I-VIII сард

Ажил үйлчилгээ	Нийт	Үүнээс:						Номын сан, (уншигчид)	Музейн үзэгчид
		Урлагийн тоглолт	Олон нийтийн ажил	Хурал цуглаан	Кино үзвэр	Уралдаан тэмцээн	Дугуйлан сургалт		
Бүгд	87	11	35	18	13	4	4	1	1
Үйлчлүүлэгчийн тоо									
Нийт	22039	3730	7661	3891	4990	768	512	208	279
Том хүн	12397	2985	4899	3729	164	523	2	23	72
Хүүхэд	9642	745	2762	162	4826	245	510	185	207

Эх үүсвэр: Соёл урлагийн ордон



## АМЬДАРЧ БУЙ ОРЧИН

2024 оны эхний 8 сард хот тохижилтын ажил үйлчилгээний нийт орлого 490.9 сая төгрөг болж, орлогын 49.5 хувийг орон сууц, 37.8 хувийг гэр хороолол, 12.7 хувийг аж ахуйн нэгжээс хуримтлуулсан орлого эзэлж, нийтдээ 93.2 мянган тонн хогийг зөөж, тээвэрлэсэн байна.

Хүснэгт 11. Хот тохижилтын үзүүлэлт, жил бүрийн I-VIII сард

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2022	2023	2024	Үүнээс:		
					Орон сууцны	Гэр хороолол	ААНБ
Нийт орлого	сая / төг	202.0	228.2	490.9	243.0	186.0	61.9
Хог тээвэрлэлт	мян / тн	38.1	36.9	93.2	29.5	38.2	25.5

Эх үүсвэр: Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГазар

2024 оны эхний VIII сард дүүргийн хэмжээнд 282.7 мянган м<sup>3</sup> ус борлуулснаас, 192.1 мянган м<sup>3</sup> (67.9%) усыг хүн амд, 90.6 мян.м<sup>3</sup> (32.1%) усыг аж ахуйн нэгж байгууллагад түгээсэн байна.



Хүснэгт 12. Орон сууц, нийтийн аж ахуйн үйлчилгээ, жил бүрийн I-VIII сард

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2020	2021	2022	2023	2024
Шахсан ус	Мян. м³	536.0	804.7	738.9	435.9	411.3
Борлуулсан ус	Мян.м³	315.7	804.2	408.8	299.8	282.7
Үүнээс: Хүн амд	Мян. м³	213.3	508.3	290.5	190.3	192.1
Аж ахуйн нэгж байгууллагад	Мян. м³	102.4	295.8	118.3	109.5	90.6
Татан зайлуулсан бохир	Мян. м³	236.3	699.5	343.5	262.7	235.3
Ус борлуулалтын орлого	Сая. төг	454.1	1 083.9	693.5	498.0	512.1
Сувагжуулалтын орлого	Сая. төг	245.2	569.4	364.5	180.0	304.3
Халаалтын орлого	сая .төг	132.5	307.1	177.4	214.5	156.9


Эх үүсвэр: Чандмань Налайх ОНӨААТҮГазар



### ГЭМТ ХЭРЭГ

Дүүрэгт 2024 оны эхний VIII сард 246 гэмт хэрэг гарсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 109 гэмт хэргээр (30.7%) буурсан байна.

Зураг 4. Гэмт хэрэгт холбогдогчид насны байдлаар




Хүснэгт 13. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг, жил бүрийн I-VIII сард

Үзүүлэлт		2020	2021	2022	2023	2024
Бүртгэгдсэн гэмт хэрэг, бүгд		251	171	252	355	246
Хүн амины	Санаатай	3	8	4	3	-
	Учрал	3	1	9	2	2
Хүчин		3	4	4	6	
Дээрэм		2	1	5	2	1
Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх		5	8	-	1	
Хулгай	Иргэдийн өмчийн	51	14	40	52	43
	Малын	11	-	-	1	



	Халаасны хулгай/ хөрөнгө завших Автомашины	1	-	1	5	6
		2	-	1	1	-
Залилан		27	13	41	92	48
Бусдын бие махбодид гэмтэл учруулсан		123	97	100	91	119
Авто тээвэр		9	5	8	10	15
Кибер аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг		-	-	1	8	3
Бусад		11	19	39	51	9
Гэмт хэрэгт холбогдогчид, бүгд		140	138	155	268	213
Үүнээс:	Ажилгүй	114	97	107	175	78
	Албан хаагч	3	3	7	6	7
	Оюутан, сурагч	5	4	12	20	16
	Малчин	-	4	4	2	7
	ТББ-ын ажилтан	3	4	2	4	6
	ХХЭ болон хувийн хэвшилд ажиллагч	12	26	23	55	99
	Хоригдол	3	-	-	-	-
	тэнэмэл	-	-	-	5	-
	Сургууль завсардсан	-	-	-	1	-
Эрүүлжүүлэгдсэн хүн		2 778	1 549	1 173	646	374
Үүнээс: Эмэгтэй		374	168	139	63	20

Зураг 5. Бүртгэгдсэн гэмт хэрэг, хороодоор



Гэмт хэргийн улмаас 5 хүн нас барж, 145 хүн гэмтэж бэртсэн бөгөөд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад нийтдээ 1 942.9 сая төгрөгийн хохирол учруулсны 1515.9 сая төгрөг буюу 78,0%-ийг нөхөн төлүүлсэн байна.

2024 оны эхний 8 сард 32328 зөрчил илрүүлж, 32038 иргэн, 11 хуулийн этгээдийг 781,0 сая төгрөгөөр торгож, 374 (эмэгтэй 20) иргэнийг эрүүлжүүлж, 124 иргэний тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хасаж, 50 иргэнийг баривчлаж, 18 иргэнийг шүүхийн шийдвэрээр баривчлуулж эрх хассан байна.

Эх үүсвэр: Цагдаагийн хэлтэс





## ТӨСӨВ

2024 оны эхний 8 сард дүүргийн төсөвт 14 206.9 сая төгрөгийн татварын орлого төвлөрч, төлөвлөгөө 1048.9 сая төгрөгөөр (7.9%) давж биелэв.

Зураг 6. Орон нутгийн татварын орлого бүрдэлт /сая.төг/



Эх үүсвэр: Татварын хэлтэс



## ТҮҮХИЙ ЭДИЙН ҮНЭ

Түүхий эдийн үнэ өмнөх оны мөн үеэс адууны дэл 2000 төгрөгөөр (28.5%), ноолуур 10000 төгрөгөөр (10.0%) тус тус буурч, үхрийн шир 5000 төгрөгөөр (50.0%), адууны шир 2000 төгрөгөөр (16.6%) тус тус өсч, адууны сүүл өмнөх оны мөн үеийн түвшинд байна.

Хүснэгт 14. Зарим түүхий эдийн үнэ, жил бүрийн VIII сард


Түүхий эдийн нэр	Хэмжих нэгж	2020	2021	2022	2023	2024
		төгрөг				
Тэмээний шир	ширхэг	35 000	17 000	-	-	30000
Адууны шир	ширхэг	12 000	12 000	8 000	12000	14000
Адууны дэл	кг	7 000	8 000	7 000	5000	3000
Адууны сүүл	кг	12 000	12 000	10 000	10000	10000
Үхрийн шир (дундаж үнэ)	2.3 метр урт хэмжээтэй ширхэг	10 000	8 000	7 500	10000	15000
Хонины арьс	ширхэг	-	2 000	-	-	-
Ямааны арьс (ноолуургүй)	ширхэг	1 500	500	-	500	-
Ямааны ноолуур	кг	-	100 000	-	110000	100000



Хүснэгт 17. Нэг литр шатахууны үнэ, төгрөг

ШТС	2023.VIII.29					2024.VIII.26				
	Аи 95	Аи 80	Аи 92	Дизель түлш	Газ	Аи 95	Аи 80	Аи 92	Дизель түлш	Газ
Жаст Ойл	-	-	2350	3680	-	-	-	2390	3390	-
Петрови с	3910	2370	2390	3730	-	3910	2370	2390	3390	-
Магнай трейд	3910	-	2390	3730	-	3910	-	2390	3390	-
Сод монгол	3910	-	2390	3730	-	3910	2315	2390	3390	-
Шунхлай	3910	-	2390	3730	-	3910	2350	2390	3390	-
Юнигаз	-	-	-	-	1790	-	-	-	3390	1790
Дундаж үнэ	3910	2370	2382	3720	1790	3910	2345	2390	3390	1790

Зураг 7. Нэг литр шатахууны дундаж үнэ VIII сард



Эх үүсвэр: Нийслэлийн статистикийн газрын 7 хоногийн үнийн судалгааны дүн



## АЖ ҮЙЛДВЭР

2024 оны эхний 8 сард үйлдвэрлэгдсэн аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад цахилгаан эрчим хүч 1.5%, дулаан хангамж 7.3%-иар өсч, усан хангамж 47.2% хувиар буурсан байна.

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалтыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад дулаан хангамж 10,7%, усан хангамж 49.2% тус тус өсч, цахилгаан эрчим хүч 5,6% буурсан байна.



Хүснэгт 18. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт, I- VIII сард

Үзүүлэлт	Хэмжих нэгж	Нийт үйлдвэрлэлт					
		Биет хэмжээгээр			Үнийн дүнгээр, сая/төг		
		2022	2023	2024	2022	2023	2024
Эрчим хүчний үйлдвэр:							
Цахилгаан	сая.квт.цаг	122.9	147.8	150.1	22 723.5	34402.5	32 486.6
Дулаан	мянган гкал	55.5	54.6	58.6	2 430.2	2 966.0	3 282.6
Усан хангамж	мянган м³	676.2	778.4	411.3	408.8	343.1	512.1
Олборлох үйлдвэр:							
Шохойн чулуу	тонн	24.1	27.8	10.3	289.4	409.7	154.9
Хайрга	мянган м³	13.3	15.6	4.8	44.9	232.2	80.0
Дайрга	мянган м³	0.2	61.5	0.4	1.1	356.6	5.5
Элс	мянган м³	134.5	24.0	29.8	477.4	284.8	451.2
Боловсруулах үйлдвэр:							
Тоосго	мян.ш	5 300.1	8143.2	3405.2	1 325.2	1 832.2	766.6
Цемент	мян.тонн	17.7	9.8	14.8	3 348.7	2 338.5	3 376.7
Бетон зуурмаг	мянган м³	6.5	12.2	17.7	1 355.4	3 121.1	4 421.7
Аюултай хог хаягдал булах	мян.тонн	0.7	0.5	0.6	982.9	805.9	750.5
Аюулгүй хог хаягдал зайлуулах	мян.тонн	45.5	81.1	93.2	544.0	871.5	1 367.0
Оёдол /сурагчийн дүрэмт хувцас/	мян.ш	15.9	12.0	11.8	570.0	475.0	745.8
Гэр ахуйн оёмол эдлэл	мян.ш	0.8	-	-	37.9	-	-
Берзинтэн цүнх, оёмол эдлэл	мян.ш	1.5	2.3	-	48.0	117.2	-
Эрдэст нунтаг	мян.тонн	0.9	3.3	5.4	64.3	193.2	317.4
Хэвлэлийн хор	мян.ш	6.8	0.3	-	335.3	20.4	-
Резинен эдлэл	сая.төг	-	-	-	-	2 623.1	3 137,2
Хүндрүүлэгч	сая.төг	-	-	-	-	10 902.5	5 600.0
Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл:							
Талх	тонн	9.3	5.0	4.3	13.2	17.2	17.6
Нарийн боов, жигнэмэг	тонн	9.0	9.4	5.8	27.3	63.4	22.0
Утсан, чанасан болон хагас боловсруулсан мах	тонн	-	5.6	-	-	39.0	-
Үхрийн мах	тонн	181.5	134.9	27.5	1 761.0	1593.2	241.4
Хонины мах	тонн	285.9	199.8	110.5	2 235.8	1803.9	820.4
Ямааны мах	тонн	33.9	14.4	0.97	215.7	112.8	5.4
Адууны мах	тонн	-	1697.7	-	-	13581.6	-
Цэвэр ус	мянган литр	10 251.0	10700.0	7604.0	3 516.8	3 930.0	2 998.5
Эрүүл мэндийн цай	мянган.кг	1.2	-	-	37.5	-	-

Эх үүсвэр: Дүүргийн аж үйлдвэрийн салбарт үйл ажиллагаа тогтмол явуулсан ААН-ын дүнгээр





## МЭДЭЭЛЭЛ, ХАРИЛЦАА ХОЛБОО

Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа холбооны байгууллага 367.8 сая төгрөгийн орлоготой ажиллаж, үүнээс 180.2 сая төгрөг (49.0%) нь хүн амд үзүүлсэн үйлчилгээний орлого эзэлж байна.

Телефон цэгийн тоо өмнөх оны мөн үеэс 42 (4.6%) цэгээр буурсан байна. Нийт суурин телефон цэгийн 467 (53.9%) нь айл өрхийн эзэмшилд байгаа бол 261 (30.1%) нь төсвийн байгууллагад, 139 (16.0%) нь бизнесийн байгууллагуудад ашиглагдаж байна.

Хүснэгт 19. Харилцаа холбооны салбарын үндсэн үзүүлэлт, жил бүрийн I-VIII сард

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2020	2021	2022	2023	2024
Нийт орлого	сая төгрөг	181.0	200.6	249.6	451.0	367.8
Үүнээс: хүн амд үзүүлсэн үйлчилгээний	сая төгрөг	88.7	98.2	122.3	221.0	180.2
Телефон цэг	тоо	731	801	971	909	867
Үүнээс: айл өрх	тоо	457	507	569	507	467
Интернет үйлчилгээний цэг	тоо	2	2	2	2	2
Интернет үйлчилгээний суудал	тоо	20	17	17	2	2
Интернет үйлчилгээний цэгээр үйлчлүүлэгчид	тоо	550	580	380	510	350
Интернетийн байнгын хэрэглэгчид	тоо	189	550	467	704	642
Таксофон	тоо	1	1	1	1	-

Эх үүсвэр: Налайх дүүргийн Холбооны газар



## АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Дүүргийн Онцгой байдлын хэлтэс 2024 оны эхний 8 сард гамшиг, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх үзлэгийг хийж нийт 170 аж ахуйн нэгж, байгууллагын объектод 756 зөрчил илрүүлэн, 621 зөрчлийг арилгуулан, гал түймрийн улсын хяналтын байцаагчийн заавал биелүүлэх албан шаардлага 96, зөрчлийн тэмдэглэл 0, ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлт 100, танилцуулга 2, гал түймэр унтраасан нотломж 58, гал түймэр гаргасан тухай акт 8, мэдэгдэл 0 хүргүүлсэн байна. Мөн объектын гал түймрийн 58 дуудлагаар ажиллаж, 11019.0 сая төгрөгийн өмч хөрөнгийг авран хамгаалсан байна.



Хүснэгт 20. Гал түймрийн дуудлагын тоо жил бүрийн I-VIII сард

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2020	2021	2022	2023	2024
Бүгд		34	27	42	44	58
Өмчийн хэлбэрээр:						
Төрийн өмч	тоо	-	-	3	1	-
Хувийн өмч	тоо	33	27	34	38	35
Аж ахуйн нэгж	тоо	1	-	5	5	23
Хамтын болон гадаад улсын өмч	тоо	-	-	-	-	-
Гал түймэрт өртөж шатсан:						
Нас барсан	хүүхэд	-	-	-	-	-
	том хүн	-	2	-	-	-
Түлэгдэж бэртсэн	хүүхэд	-	-	-	-	-
	том хүн	-	-	-	-	-
Өвөл зуны сууц	тоо	14	3	8	15	26
Гэр	тоо	4	6	11	18	12
Хог, хогийн суваг	тоо	4	4	8	11	8
Машин техник	тоо	7	1	5	-	7
Барилга байгууламж	тоо	1	1	7	-	3
Малын хашаа саравч	тоо	-	-	3	-	2
Бусад	тоо	4	13	-	-	-
Шалтгаан:						
Цахилгааны	тоо	6	5	20	22	38
Ил задгай асгасан үнс, нурмаас	тоо	2	8	7	6	-
Лаа, тамхи, шүдэнз	тоо	-	4	2	4	-
Пийшин зуухны цонолт	тоо	1	2	6	12	10
Машин техник гэмтэл, буруу ашигласан	тоо	1	2	2	-	6
Машин, техникийн яндангийн оч болон цахилгааны очноос	тоо	2	-	-	-	-
Архидан согтуурснаас	тоо	2	-	-	-	1
Бусад	тоо	1	2	5	-	-
Шалтгаан тогтоогдоогүй	тоо	10	3	-	-	3
Аварсан эд хөрөнгө:						
Хүн	тоо	4	-	-	-	-
Өвөл зуны сууц	тоо	8	6	3	6	5
Гэр	тоо	3	-	-	-	6
Барилга байгууламж	тоо	5	-	9	3	6
Нийтийн орон сууц	тоо	-	-	-	-	1
Машин техник	тоо	3	1	5	3	4
Улсын онц чухал болон галын онц аюултай объект	тоо	1	-	-	-	1
Малын хашаа саравч	тоо	-	-	3	-	1
Эд хөрөнгө	сая төгрөг	614.0	321.0	1 645.0	1 697.7	11 019.0

Эх үүсвэр: Онцгой байдлын хэлтэс 2024 оны эхний 8 сард дүүргийн Засаг даргын 11 удаагийн захирамжаар нийт 1119 иргэн, аж ахуйн нэгжийн захирамж гарсанаас 1075 иргэн, 44 аж ахуйн нэгж, албан даргын 38 удаагийн тушаалаар нийт 1097 иргэн, аж ахуйн захирамж гарснаас 1044 иргэн, 53 аж ахуйн нэгж байгууллагатай холбоотой асуудлыг шийдвэрлэсэн



байна. Мөн Нийслэлийн Засаг даргын 5 удаагийн захирамжаар газар өмчлөх хүсэлт гаргасан 56 хамтран өмчлөгч хасуулах 25 иргэний асуудлыг шийдвэрлэсэн.

Хүснэгт 21. Газартай холбоотой асуудал шийдвэрлэлт, жил бүрийн I-VIII сард

Зориулалт	Газрын хэмжээг өөрчлөх	Газар эзэмших эрхийг хүчингүй болгох	Газар эзэмших эрх олгох, баталгаажуулах	Газар эзэмших эрхийг шилжүүлэх	Газар өмчлөх	Хамтран өмчлөгч хасуулах	Газрын байршил өөрчлөх	Газар ашиглуулах эрх олгох	Газар эзэмших эрхээ цуцлуулах хүсэлт гаргасан
Иргэн, ААНБ-ын тоо	18	187	818	1000	56	25	96	97	0

Эх үүсвэр: Газар зохион байгуулалтын алба



### ӨРГӨДӨЛ ГОМДОЛ, ШИЙДВЭРЛЭЛТ

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл, гомдлыг бүртгэх, шилжүүлэх, шийдвэрлэх, хариу өгөх, хяналт тавих, тайлагнах ажлыг “Өргөдөл, гомдлын нэгдсэн программ”-аар явуулж байгаагийн зэрэгцээ “Налайх сонсож байна” 7023-2727, 1800-1200 тусгай дугаарын утас, Засгийн газрын 11-11 утас, [www.ub1200.mn](http://www.ub1200.mn) цахим хуудас, Check my service аппликейшн зэргээр иргэдийн гомдол, хүсэлт, саналыг хүлээн авч байна.

2024 оны эхний 8 сард дүүргийн Засаг Даргын Тамгын газарт нийт 1969 санал, хүсэлт, өргөдөл хүлээн авсан байна. Эдгээрээс 1938 санал, хүсэлт, өргөдөлд хариу өгч, 2 бичиг хугацаа хэтэрч шийдвэрлэсэн, 29-д хариу өгөх хугацаа болоогүй болон судлагдаж байна. Санал хүсэлтийн шийдвэрлэлт 98.0 хувьтай байна. Ирсэн өргөдөл, гомдол, саналын 1581 (80.3%) нь бичгээр, 388 (19.7%) нь утсаар ирсэн байна.

Эх үүсвэр: ЗДТГ-ын Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн мэдээ

Танилцуулгыг татаж авах линк :

[www.ubstat.mn](http://www.ubstat.mn)

Налайх дүүргийн  
Статистикийн хэлтэс  
facebook page

Утас: 7023-3672

УБ хот, Налайх дүүрэг ЗДТГ-ын байр 2 давхар 210 тоот





НАЛАЙХ ДҮҮРГИЙН  
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

## ECO mobility аянг нэгдэж байна



- ГЭР ОЙРХОН ХҮМҮҮС АЛХАХ
- ЦАХИЛГААН БОЛОН УНАДАГ  
ДУГУЙ УНАХ
- НИЙТИЙН ТЭЭВРЭЭР ЗОРЧИХ
- НЭГ ЧИГЛЭЛД ЗОРЧДОГ ХҮМҮҮС  
МАШИНАА ХУВААЛЦАХЫГ  
УРИАЛЖ БАЙНА